

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/92-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2023 он	Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16-17
4. Аудитын тайлан	18-20
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23-24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.24 № СЭА-2023/92-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 99.2 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшлыг 0.8 хувиар, НДШ-ийг 2.0 хувиар, тогтмол зардлыг 0.3 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, батлагдсан төсвийг 0.8 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 66.7 хувийг цалин хөлс болон нэмэгдэл

урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 56,591.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 141,142.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,140,866.23	48,572,981.00
35	БАРАА МАТЕРИАЛ	42,140,866.23	48,572,981.00
35100	Түүхий эд материал	7,867,210.00	8,167,210.00
35110	Тусгай зориулалттай материал	7,867,210.00	8,167,210.00
35400	Хангамжийн материал	34,273,656.23	40,405,771.00
35410	Бичиг хэргийн материал	129,800.00	129,800.00
35420	Аж ахуйн материал	28,690,856.23	35,035,971.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,232,000.00	2,232,000.00
35440	Түлш, шатах тослох материал	213,000.00	0.00
35450	Барилгын засварын материал	3,008,000.00	3,008,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	769,461,833.41	724,704,547.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	769,461,833.41	724,704,547.05
39200	Биет хөрөнгө	719,959,833.41	675,202,547.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	596,803,135.60	596,803,135.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,779,249.18	-49,938,820.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5,385,416.74	-8,322,916.78
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	102,968,374.28	108,423,974.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,659,847.73	-35,504,396.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,701,978.00	56,701,978.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,226,485.66	-25,494,512.94
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,684,631.00	18,684,631.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,722,286.16	-9,725,525.52
39217	Ном	75,000.00	75,000.00
39300	Биет бус хөрөнгө	49,502,000.00	49,502,000.00
39301	Програм хангамж	563,340.00	563,340.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-563,340.00	-563,340.00
39303	Бусад биет бус хөрөнгө	49,502,000.00	49,502,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	811,602,699.64	773,277,528.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	811,602,699.64	773,277,528.05
51	Засгийн газрын хувь оролцоо	811,602,699.64	773,277,528.05
51100	Засгийн газрын оруулсан капитал	200,497,379.82	200,497,379.82
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	200,497,379.82	200,497,379.82
51200	Хуримтлагдсан үр дүн	31,665,455.11	-6,659,716.48
51210	Өмнөх үеийн үр дүн	-13,675,660.60	31,665,455.11
51220	Тайлант үеийн үр дүн	45,341,115.71	-38,325,171.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	579,439,864.71	579,439,864.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	811,602,699.64	773,277,528.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	574,702,883.56	734,658,613.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,466,395.00	6,157,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	60,466,395.00	6,157,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	60,466,395.00	5,455,600.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	701,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	514,236,488.56	728,501,113.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	415,207,600.00	687,924,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	687,924,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	415,207,600.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,800,000.00	40,577,013.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	11,907,093.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,800,000.00	28,669,920.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,228,888.56	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,228,888.56	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	529,361,767.85	772,983,784.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	529,361,767.85	772,983,784.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	525,552,130.46	767,204,835.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	178,215,870.35	406,623,127.78
210101	Үндсэн цалин	113,623,798.46	338,036,892.42
210102	Нэмэгдэл	33,108,797.72	27,245,976.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,353,609.61	17,594,500.00
210104	Урамшуулал	20,129,664.56	23,745,759.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,009,561.45	50,262,093.99
210201	Тэтгэврийн даатгал	15,474,654.32	34,082,306.41
210202	Тэтгэмжийн даатгал	1,729,377.43	4,411,522.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,383,501.97	3,209,729.80
210204	Ажилгүйдлийн даатгал	311,093.50	977,021.32
210205	Эрүүл мэндийн даатгал	3,110,934.23	7,581,513.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,116,888.56	56,591,377.90
210301	Гэрэл, цахилгаан	2,523,823.91	4,007,224.32
210302	Түлш, халаалт	31,154,782.65	48,986,496.58
210303	Цэвэр, бохир ус	1,438,282.00	3,597,657.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,874,281.14	5,029,172.90
210401	Бичиг хэрэг	3,842,600.00	725,560.00
210402	Тээвэр, шатахуун	3,052,980.14	1,373,483.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,993,746.00	2,489,279.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	440,850.00
210408	Бараа материал акталсны зардал	12,984,955.00	0.00
2105	Нормативт зардал	260,000.00	189,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	260,000.00	189,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,552,000.00	12,734,900.00
210604	Урсгал засвар	9,552,000.00	12,734,900.00
2107	Томилолт, зочны зардал	2,736,400.00	487,450.00
210702	Дотоод албан томилолт	2,736,400.00	487,450.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	244,823,986.44	180,449,827.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	244,391,986.44	179,954,027.03
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	63,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	35,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	46,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,963,142.52	54,837,586.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,466,000.00	4,624,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,497,142.52	50,212,886.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,809,637.39	5,778,948.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	330,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	330,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	5,448,948.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	5,448,948.63
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,809,637.39	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,809,637.39	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	45,341,115.71	-38,325,171.59
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	45,341,115.71	-38,325,171.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	514,236,488.56	728,501,113.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	514,236,488.56	728,501,113.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	415,207,600.00	687,924,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	687,924,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	415,207,600.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,800,000.00	40,577,013.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	11,907,093.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,800,000.00	28,669,920.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,228,888.56	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,228,888.56	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	514,161,488.56	723,052,164.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514,161,488.56	723,052,164.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	510,351,851.17	716,273,215.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	178,202,270.35	406,619,127.78
210101	Үндсэн цалин	113,610,198.46	339,744,092.42
210102	Нэмэгдэл	33,108,797.72	25,461,276.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,353,609.61	17,668,000.00
210104	Урамшуулал	20,129,664.56	23,745,759.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,009,561.45	50,262,093.99
210201	Тэтгэврийн даатгал	15,474,654.32	34,082,306.41
210202	Тэтгэмжийн даатгал	1,729,377.43	4,411,522.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,383,501.97	3,209,729.80
210204	Ажилгүйдлийн даатгал	311,093.50	777,721.32
210205	Эрүүл мэндийн даатгал	3,110,934.23	7,780,813.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,116,888.56	56,591,377.90
210301	Гэрэл, цахилгаан	2,523,823.91	4,007,224.32
210302	Түлш, халаалт	31,154,782.65	48,986,496.58
210303	Цэвэр, бохир ус	1,438,282.00	3,597,657.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,891,226.00	6,138,939.70
210401	Бичиг хэрэг	3,909,900.00	837,560.00
210402	Тээвэр, шатахуун	3,265,980.00	1,024,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,715,346.00	2,560,479.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,716,000.00
2105	Нормативт зардал	728,000.00	189,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	728,000.00	189,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,112,000.00	14,337,100.00
210604	Урсгал засвар	13,112,000.00	14,337,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,708,400.00	416,250.00
210702	Дотоод албан томилолт	2,708,400.00	416,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	248,117,504.81	176,270,726.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	247,685,504.81	176,099,626.37
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	63,800.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	35,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	46,900.00
210807	Газрын төлбөр	0.00	25,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,466,000.00	5,448,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,466,000.00	5,448,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,809,637.39	6,778,948.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,330,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,330,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	5,448,948.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	5,448,948.63
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,809,637.39	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,809,637.39	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	75,000.00	5,455,600.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	75,000.00	5,455,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	75,000.00	5,455,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	75,000.00	5,455,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	75,000.00	5,455,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-75,000.00	-5,455,600.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	200,497,379.82	579,439,864.71	31,665,455.11	811,602,699.64
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	31,665,455.11	811,602,699.64
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-38,325,171.59	-38,325,171.59
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	-6,659,716.48	773,277,528.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	687,924,100.00	682,475,151.37	5,448,948.63	99.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	687,924,100.00	682,475,151.37	5,448,948.63	99.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	686,573,100.00	681,145,151.37	5,427,948.63	99.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,125,400.00	406,619,127.78	3,506,272.22	99.15
210101	Үндсэн цалин	344,926,500.00	339,744,092.42	5,182,407.58	98.50
210102	Нэмэгдэл	46,970,900.00	25,461,276.36	21,509,623.64	54.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,228,000.00	17,668,000.00	560,000.00	96.93
210104	Урамшуулал	0.00	23,745,759.00	-23,745,759.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,265,600.00	50,262,093.99	1,003,506.01	98.04
210201	Тэтгэврийн даатгал	35,453,900.00	34,082,306.41	1,371,593.59	96.13
210202	Тэтгэмжийн даатгал	3,952,900.00	4,411,522.71	-458,622.71	111.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,162,300.00	3,209,729.80	-47,429.80	101.50
210204	Ажилгүйдлийн даатгал	790,600.00	777,721.32	12,878.68	98.37
210205	Эрүүл мэндийн даатгал	7,905,900.00	7,780,813.75	125,086.25	98.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,736,100.00	56,591,377.90	144,722.10	99.74
210301	Гэрэл, цахилгаан	4,296,900.00	4,007,224.32	289,675.68	93.26
210302	Түлш, халаалт	49,047,500.00	48,986,496.58	61,003.42	99.88
210303	Цэвэр, бохир ус	3,391,700.00	3,597,657.00	-205,957.00	106.07
2104	Хангамж, бараа материалын зардал	6,141,500.00	6,138,939.70	2,560.30	99.96
210401	Бичиг хэрэг	838,500.00	837,560.00	940.00	99.89
210402	Тээвэр, шатахуун	1,025,600.00	1,024,900.00	700.00	99.93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,561,400.00	2,560,479.70	920.30	99.96
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,716,000.00	1,716,000.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	530,200.00	189,300.00	340,900.00	35.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	530,200.00	189,300.00	340,900.00	35.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,337,100.00	14,337,100.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	14,337,100.00	14,337,100.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	433,700.00	416,250.00	17,450.00	95.98
210702	Дотоод албан томилолт	433,700.00	416,250.00	17,450.00	95.98
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	141,555,200.00	141,142,662.00	412,538.00	99.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	140,997,500.00	140,971,562.00	25,938.00	99.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	386,600.00	0.00	386,600.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	63,800.00	63,800.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,100.00	35,100.00	0.00	100.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	46,900.00	46,900.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	25,300.00	25,300.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,448,300.00	5,448,300.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,448,300.00	5,448,300.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,351,000.00	1,330,000.00	21,000.00	98.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,351,000.00	1,330,000.00	21,000.00	98.45
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,351,000.00	1,330,000.00	21,000.00	98.45
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	687,924,100.00	687,924,100.00	0.00	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	687,924,100.00	687,924,100.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	687,924,100.00	687,924,100.00	0.00	100.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	31	31	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	15	15	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	15	15	0.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15	15	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		40,577,013.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		40,577,013.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		40,577,013.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		40,577,013.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		40,577,013.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		40,577,013.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		40,577,013.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		11,907,093.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		28,669,920.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар *Цаашид ГБХЗХГ гэхл* нь “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжин, иргэн бүрд хүрсэн шуурхай үйлчилгээг бий болгох” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хүүхдийн эрхийн тухай, хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, сурталчлах, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах,
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, төлөвлөгөө хөтөлбөр гаргах, үе шаттай зохион байгуулах,
- Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэхэд олон улсын болон мэргэжлийн байгууллагаас арга зүй, туслалцаа дэмжлэг авах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, зорилтод дуудлагын хариу үйлчилгээний чанарыг сайжруулах,
- Өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн зусланг хүүхдийн амралт, аялал жуулчлал, сувилал, чийрэгжүүлэлтийн болон оюун ухаан, авьяас чадварыг хөгжүүлэх, амьдрах ухаанд суралцуулах, гэр бүлтэйгээ амрах чиглэлээр төрөлжсөн үйл ажиллагаа хувилбарт хөтөлбөр бүхий үйлчилгээний цогцолбор болгоход чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх,
- Хүүхэд залуучуудыг соёл урлаг, спортоор дамжуулан хөгжүүлэх, амьдрах арга ухаанд суралцуулах хөгжлийн үйл ажиллагааг хүүхдийн ордон, залуучуудын хөгжлийн төв болон бусад байгууллагыг түшиглэн орон нутагт хэрэгжүүлэхэд бодлого, удирдамж, арга зүйгээр ханган ажиллах,
- Эцэг эх, хүүхэд, залуучууд иргэд олон нийтэд зориулсан цахим болон алсын зайн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж, түгээх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах,
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын үйлчилгээ, үйл ажиллагааг мэргэшсэн магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага, хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж, үр дүнг тооцох, нийтэд мэдээлэх,
- Эрсдэлтэй бүлгийн хүүхдийн эрхийг хамгаалах, дахин эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх үйлчилгээг сайжруулах,
- Хүүхдийн үндэсний болон орон нутгийн чуулганыг тогтмолжуулж, чуулганы шийдвэрийг бодлого, төлөвлөлтөд тусгах,
- Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнд хүүхэд, эцэг эх, хүүхдийн элчийн төлөөллийг оруулах, хүүхдийн элчийн үйл ажиллагааг төлөвшүүлэх,
- Хүүхэд залуучуудын сонирхлын бүлэг, клуб холбоо зэрэг байгууллагын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах,
- Хүүхэд өсвөр үеийнхнийг хэвлэл мэдээлэл, цахим дахь мэдээллийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, эцэг эхийн оролцоотой хяналтыг төлөвшүүлэх,

- Монгол хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, үнэлэх аргачлал боловсруулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Хүүхэд хамгааллын тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Гэр бүлийн тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хүүхдийн эрхийн тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 06 дугаар сарын 28-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

ГБХЗХГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын Мэдээллийн технологи, хяналт, шинжилгээ, үнэлгээний газраас 2022 оны 06 дугаар сарын 16-наас 18-ны хооронд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төсөв, хөрөнгө оруулалт, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 9 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж, ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ГБХЗХГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар ГБХЗХГ-ын төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ГБХЗХГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,325.2 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	42,140.9	48,573.0	6,432.1
Үндсэн хөрөнгө	769,461.8	724,704.5	-44,757.3
Нийт хөрөнгө	811,602.7	773,277.5	-38,325.2
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	811,602.7	773,277.5	-38,325.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	811,602.7	773,277.5	-38,325.2

Бараа материалын дансны үлдэгдэл 48,573.0 мянган төгрөг болж 6,432.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 138,038.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 401.9 мянган төгрөгийн материалыг шилжүүлэн авсан

болон 132,008.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 854,254.1 мянган төгрөг болж 5,455.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 773,277.5 мянган төгрөг болж 38,325.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 987,773.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 289,448.4 мянган төгрөгөөр бууруулж /Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 375,603.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 79,909.2 мянган төгрөгөөр тус тус бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 211,485.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь голлон нөлөөлсөн байна./ 698,324.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 10,400.7 мянган төгрөгөөр бууруулж төсвийн зохицуулалт /Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 225,886.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 27,922.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 212,082.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан нь голлон нөлөөлсөн байна./ хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 687,924.1 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 687,924.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 682,475.1 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн зардлыг 5,446.9 мянган төгрөгөөр, залуучууд болон оюутнууд хөтөлбөрийн зардлыг 2.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Хүүхдийн хөгжил, хамгаалал	655,336.7	649,889.8	5,446.9	99.2
2	Залуучууд болон оюутнууд	22,908.5	22,906.4	2.1	100.0
3	Гэр бүлийн хөгжил, хамгаалал	9,678.9	9,678.9	0.0	100.0
	Дүн	687,924.1	682,475.1	5,449.0	99.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130017401 тоот дансанд ХНХЯ-аас 3,244.6 мянган төгрөг, АХБ-аас хэрэгжүүлж буй Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслөөс 8,662.5 мянган төгрөг, ГБХЗХГ-аас хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт 28,669.9 мянган төгрөг зэрэг нийт 40,577.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ГБХЗХГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ГБХЗХГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 529,361.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,293.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2022 оны 01/55 дугаар “Хуулийн хэрэгжилтийн талаар”, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/377 дугаар албан бичгийг хэрэгжүүлж дараах арга хэмжээг авсан байна. Үүнд:

- *Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,*
- *Чиг үүрэг, орон тоог давхардуулаагүй ажилласнаар цалингийн сан хэмнэгдсэн,*

- *Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй,*
- *Тайлант онд хэвлэл захиалга хийгээгүй,*
- *Байгууллагын цахилгааны хэрэглээнд албан хаагчдыг хэмнэлттэй байх үүрэг даалгавар өгч үр ашиггүй зардал гаргахгүй ажилласан гэх мэт.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ГБХЗХГ-ын мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн боловч 48,873.2 мянган төгрөгийн 7 *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ* мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримт болон зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсантай холбоотой 3,927.4 мянган төгрөгийн албан шаардлага, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, үндсэн цалин, хоолны хөнгөлөлтийг зөрүүтэй тооцоолсонтой холбоотой 119,467,8 мянган төгрөгийн зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	3,927.4	2	3,927.4	100
Зөвлөмж	2	115,540.4	2	115,540.4	100
Нийт дүн	4	119,467,8	4	119,467,8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 50,212.9 мянган төгрөгийн төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Тайлант хугацааны 50,212.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцоогүй.

Аудитаар нийт 20,029.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,760.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,677.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 16,591.5 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. ХНХЯ-аас зохион байгуулсан "Хүүхдийн эрх, хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал"-ын сургалтыг тус газрын сургалтын танхимд зохион байгуулсан боловч заал түрээсэлсэн гэж "Нисдэг оточ" ББН-д **1,760.0** мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д *"Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, ... болон холбогдох бусад зардлыг хэмнэх"* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүй гарсан зардлыг нөхөн төлөх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Анхан шатны баримтыг огт бүрдүүлэлгүйгээр дараах **1,677.5** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- Хүүхдийн баярын арга хэмжээнд зарцуулсан 1,227.5 мянган төгрөг,
- Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллуулахад зарцуулсан 450.0 мянган төгрөг.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"*, 20 дугаар зүйлийн 20.1.4-т *"хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр, баталгаажсан анхан шатны баримтад үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэн, бүртгэл, тайланд тусгаж байх албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар дараах **16,591.5** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, спидометрийн заалтыг бичээгүй 4,631.6 мянган төгрөг,
- Хүүхдийн эрх, хамгааллын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалын сургалтад оролцогчдын 1,620.0 мянган төгрөгийн хоолны тооцоог гарын үсгээр баталгаажуулаагүй,
- Түр хамгаалах байрны хоолны зардал 4,301.3 мянган төгрөг, материалын зардал 6,132.2 мянган төгрөг зэрэг нийт 10,339.9 мянган төгрөгийн бараа материалын зарцуулалтын гүйцэтгэлийн тайлан гаргаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн.		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцоогүй.	1	50,212.9	1	50,212.9			1	50,212.9					
Дүн	1	50,212.9	1	50,212.9			1	50,212.9					

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндэслэлгүй төлбөр шилжүүлсэн.	1	1,760.0	1	1,760.0								
Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан	1	1,677.5			1	1,677.5						
Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан	1	16,591.5					1	16,591.5				
Дүн	3	20,029.0	1	1,760.0	1	1,677.5	1	16,591.5				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Шилэн дансны мэдээллийг огт мэдээлээгүй.	7	48,873.2			7	48,873.2	
Дүн	7	48,873.2			7	48,873.2	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Дүн							
Нийт дүн	7	48,873.2			7	48,873.2	